

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ХОЛБООНЫ 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны ээлжит 9-р хурал 2014 оны 09-р сарын 02-ны өдөр Мандалговь хотноо болж тус холбооны гишүүнээр бүртгэлтэй бүх хоршоодоос сонгогдсон төлөөлөгчид оролцож, аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо болон хоршоологчдын өнөөгийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудалаа хэлэлцсэн.

Хурлаас хойш нэг жил гаруй хугацаанд бид юу хийж бүтээв, цаашид юу хийх талаар энэ тайланд тусгаж байна. Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны ажил сүүлийн жилүүдэд зогсонги байсан, түүнийг засах сайжруулах талаар хурлын төлөөлөгчид хангалттай ярилцсан, зохих шийдвэрүүдийг гаргасан.

ХААХХ-ны 9-р бага хурлаас гарсан шийдвэрийг хоршоологчдод хүргэн сурталчилж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг хоршоодын дарга тэргүүлэгч нарт үүрэг болгож бага хурлаас 01 дугаар тогтоол гаргаж, түүнийг хэрэгжүүлэх зорилт тавьж ажилласан.

Мөн аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дүрмийн 19-3-т аймгийн холбооны элсэлтийн татвар 50000 төгрөг, жил бүрийн татвар 120000 төгрөг байхаар өөрчлөлт оруулсан ч 2015 он эдийн засгийн хямралтай, ажил орлого бага байгаагаас гишүүн хоршоод татвараа бүрэн төлж чадахгүй байна. Аймгийн холбооны зүгээс хоршоодоос татвар авахыг урьдал болголгүй, тэдэнд хүрч ажиллах, мэдээлэлээр хангах, урам өгөх талаар түлхүү анхаарч ажиллаж байна.

Хуралд оролцсон төлөөлөгчид хоршоодын өнөөгийн хөгжлийн түвшин хангалтгүй, санхүүжилт хомсдолтой байгаа, хоршооны төслүүд хэрэгжихгүй байгааг шүүмжилж, ажил сайжруулах талаар санал бодлоо илэрхийлж ярилцсан. Цаашид аймаг сум хөгжүүлэх сангийн 50-80 хувийг хоршоодод олгож байх талаар төлөөлөгчидийн санал болон хоршоо хөгжүүлэх аймгийн хөтөлбөрийн заалт, МХААХҮХ-ны ерөнхийлөгч, аймгийн засаг дарга нарын гарын үсэг зурсан санамж бичгийн дагуу аймаг орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн зээл болон бусад төсөл, хөтөлбөрүүд хамруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

Мөн хоршооны гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ялангуяа ноос, арьс ширний урамшуулалыг зөвхөн хоршоогоор дамжуулж олгодог байх хууль, журмыг мөрдөх, хоршоодыг зэрэг дэвээр нь хамтарч ажиллах боломжийг олгох зэрэг асуудлуудыг үндсэний холбоогоор дамжуулан төр, засагт хүргэхийг санал болгосон. Эдгээр арга хэмжээнүүд зогсонги байсан холбооны ажлыг хөдөлгөөнд оруулах, аймгийн хөдөө аж ахуйн холбоо түүний гишүүн хоршоодын ажлын уялдаа холбоо сэргэх эхлэл болсон.

Мөн энэ бага хурлаас шийдвэр гаргасан гол ажил болох аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 1960 оны үед баригдаж сууриас 1.0 м орчим ялзарч муудсан, суулт гажилт үүссэн олон жил ашиглаагүй барилгыг бүтэн шинэчлэж шинээр барьж дуусгасан нь гишүүн хоршоодын урамыг сэргээсэн энэ **оны онцлох ажил** болов.

Бид аймгийн Холбооны байрыг иж бүрэн шинэчлэн засварлах, дулааны болон цэвэр усны шугам сүлжээний зураг төсвийг хийлгэж, үүний дагуу 2014 онд холбооны хуучин байрыг бүрэн нурааж, бетон фундаментыг нь сайжруулан ашиглаж, бетон шал цутгаж шинээр палка болон блокоор хурлын заал, мансард бүхий барилгын их бие, дээвэр, гадна

ажлыг хийж эхэлсэн боловч хөрөнгө байхгүй учир энэ ажил олон жил сунжирч дуусдаггүй барилгатай хоцрох бий гэдэг болгоомжлол олон хүнд байсан.

Гэвч бид Үндэсний холбооныхоо дэмжлэгтэйгээр нийт 120 квадрат метр ашигтай талбай бүхий офиссын 2 өрөө, хурлын заал, ариун цэвэрийн 2 өрөөтэй, мансардын 30 квадрат метр талбай бүхий өрөөнд зочид буудал байгуулж тохижуулсан барилгыг шинээр барьж 2015 оны 6-р сарын 19-ны өдөр нээлтээ хийж ашиглалтанд оруулсан.



Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны шинэ байрны нээлт

Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны ээлжит 9-р хурлаас хойшхи хугацаанд холбооноос хийсэн ажлыг товч тайлагнаж байна.

### ***1. Хоршоог хөгжүүлэх, тэдгээрийн менежментийг боловсронгуй болгох талаар***

Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2009 оны 177-р тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу “Дундговь аймагт хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг бүх сумын засаг дарга нар болон гишүүн хоршоодын дарга нарт даалгаж аймгийн засаг даргын албан тоотор хүргүүлсэн нь үр дүнгээ өгч аймаг орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн зээл болон бусад төсөл, хөтөлбөрүүд 10 гаруй хоршоо хамрагдан ажиллаж байна. Харин улс орон даяар эдийн засгийн хямрал үүссэн, зээл хязгаарлах зарим шийдвэрээс хамаарч хоршоодын зээлийг банкууд олгохгүй ихээхэн хүлээлт үүсгэж ажил, орлогыг гацааж байна.

Аймгийн хэмжээнд Хөдөө аж ахуйн 26 хоршоо, түүхий эд бэлтгэн нийлүүлэх 16 хоршоо, Хадгаламж зээлийн 3 хоршоо ажиллаж байгаа бөгөөд эдгээрээс одоогоор 27 хоршоо аймгийн ХААХХолбооны гишүүний бүртгэлтэй байна.

Ялангуяа 2014-2015 онд гишүүн хоршооны тоо нэмэгдсэн нь холбооноос зохион байгуулсан зарим ажил арга хэмжээний үр дүнг илтгэх үзүүлэлт гэж ойлгож байна. Дэд хөтөлбөрийг батлуулж, аймгийн засаг даргатай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан нь хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршоологчдийн эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр буй болгох, хоршоод ажлаа сурталчлах боломж бүрдсэн.

2015 онд Адаацаг сумын Амьдралын туг хоршоо Улсын тэргүүний хоршоогоор шалгарсан нь Эрдэнэдалай сумын “Далайн хөгжил”, Гурвансайхан сумын “Давших зам”, Сайнцагаан сумын “Аравжих далай”, Дэрэн сумын “Наран хөгцгий”, Луус сумын “Шинэ хөдөлмөр”, Дэлгэрцогт сумын “Ширээс” зэрэг олон хоршоо, хоршоологчдын урам зоригыг сэргээсэн, тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн, нөгөө талаас хоршоологчдын хийсэн бүтээсэнийг МХААҮХолбоо болон улсаас үнэлэж дүгнэдэгийг орон нутагт мэдрүүлсэн үйл явдал болсон.



Адаацаг сумын Амьдралын туг хоршооны дарга Ж.Тувааннайdan  
Улсын тэргүүний хоршооны хаягаа гардан авч байгаа нь

Амьдралын туг хоршооны үйл ажиллагааг бусад сумдын хоршоо, хоршоологчдод сурталчилах, газар дээр нь очуулж танилцуулах, малчид, гишүүдын санал хүсэлтыг сонсох, Улсын тэргүүний хоршооны дарга, нягтлан нараар заавар зөвлөлгөө өгүүлэх ажлуудыг зохион байгуулсан.

Мөн Амьдралын туг хоршоо өөрийнхөө зардлаар шилдэг малчид, ажилчидаа Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, үндэсний холбооны үйл ажиллагаа болон УИХ-ын явц, төрийн ордонтой танилцуулсан аялал зохион байгуулсан нь хоршоологчдын талархалыг хүлээж байна.

Зарим хоршоодоос иймэрхүү аялалыг аймгийн холбоо зохион байгуулж жил бүр тодорхой хүмүүсийг орон нутагт аялуулж байхыг санал болгосон. Энэ нь манай гишүүн хоршоологчдын урам зориг сэргэж байгааг нэг илэрхийлэл гэж ойлгож байна.

## **2. Хоршоодын хүний нөөцийг хөгжүүлэх талаар**

2015 оны 6-р сарын 19-20-ны өдөр Мандалговь хотод 25 хоршоодын удирдлагад удирдах арга, хоршооны менежментыг боловсронгуй болгох, хоршоодын брэнд бүтэгдэхүүнийг шалгаруулах, уг бүтэгдэхүүнийг сурталчлах талаар сургалт зохион байгуулсан. 2015 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Төр, хувийн хэвшлийн түгшлэл болон нийгмийн өмнө хүлээх хариуцлагын асуудлаар мэргэшсэн үндэсний зөвлөх” мэргэжилтэн бэлтгэх сургалтанд холбооны зарим удирдлага оролцож, энэ чиглэлээр үндэсний зөвлөх мэргэжилтэний эрхийн батламж авсан.

Сайхан-Овоо суманд аймгийн ХААЖДҮГ-аас зохион байгуулсан чацаргага тарих, газар тариалан эрхлэх чиглэлийн сургалтанд зарим хоршооны гишүүдийг хамруулсан.

2015 онд Улаанбаатар хотод Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний Холбоо, “НАМАК” ХХК-аас зохион байгуулсан сургалтуудад Баянжаргалан, Дэрэн, Хулд, Өндөршил, Эрдэнэдалай сумдын хоршоод оролцсон.

## **3. Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний Холбооноос зохион байгуулсан ажилд оролцсон талаар**

Монголын Хөдөө аж үндэсний холбоо, Булган аймгийн Засаг даргын тамгын газар, Булган аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газар хамтран зохион байгуулсан “Төр-Хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” сэдэвт хөдөө аж ахуйн хоршоологчдын Төв Хангайн бүсийн зөвлөгөөнд тус аймгийн Адаацаг, Сайнцагаан, Луус, Хулд сумдын гишүүн хоршоодын төлөөлөгчдийн хамт холбоо өөрсдийн зардлаар явж оролцсон. Зөвлөгөөнд оролцсон манай төлөөлөгчид Төр-хоршооллын хамтын ажиллагаа сэдэвээр зөвлөлдөх 3 ажлын хэсэгт хуваагдан оролцож, нэгдсэн хуралдаанд санал бодолоо илэрхийлсэн.



Төв Хангайн бүсийн зөвлөгөөнд оролцсон Адаацаг, Сайнцагаан, Луус,

Хулд сумдын гишүүн хоршоодын төлөөлөгчид



Монголын Хөдөө аж үндэсний холбоо болон зохион байгуулагчид Сэлэнгэ сумын хошоод, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, Эрдэнэт хот, ГОК-ын уул уурхайн үйл ажиллагаа болон Эрдэнэт хивс ХХК-тай танилцуулсанд төлөөлөгчид баяртай байв.

“Тогтвортой хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Хоршоологчдын Үндэсний IV чуулганы шийдвэрийг аймгийнхаа хөдөө аж ахуйн хоршоо, хоршоологчдод хүргэх сурталчлах ажлыг дэс дараатай зохион байгуулж ажиллаа. Үүнд:

Үндэсний Холбооны VII Их хуралд аймгийн бага хурлаас сонгогдсон холбооны тэргүүн Д.Чандмань-Сайнцагаан, Луус, Хулд сум, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн хоршоо хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяр-Говь-Угтаал, Баянжаргалан, Цагаандлгэр сум, Адаацаг сумын “Амьдралын туг” хоршооны дарга Ж.Тувааннайдан - Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн сум, Өлзийт сумын “Рашаантын Аж Богд” хоршооны дарга Д.Жаргалсайхан – Өлзийт, Өндөршил, Гурвансайхан сум, Эрдэнэдалай сумын “Далайн хөгжил” хоршооны дарга Д.Мөнхбаатар – Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдыг тус тус хариуцан авч чуулганы шийдвэрийг хоршоологчдод хүргэх сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.



Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний Холбооноос өгсөн үүргийн дагуу НҮБ-ийн ХХАА-н байгууллагын Ази-Номхон далайн бүсийн байгууллагаас 2015 оны 11-р сарын 24-26-ны хооронд Тайланд улсын Бангкок хотноо зохион байгуулсан “Ази-номхон далайн бүсийн агро-экологийн асуудлаарх төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтарсан зөвлөлдөх уулзалт”-нд Үндэсний холбоог төлөөлж Д.Чандмань миний бие оролцож монгол орны бэлчээрийн ашиглалтын талаар илтгэл тавьж, танилцуулга хийсэн. Зөвлөлдөх уулзалтын үеэр оролцогч талуудын хооронд туршлага солилцох замаар бүс нутгийн агро-экологийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч цаашид анхааран хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцсон.



Ази-номхон далайн бүсийн агро-экологийн асуудлаарх салбар хуралдаан



НҮБ-ийн ХХАА-н байгууллагын Ази-Номхон далайн бүсийн байгууллагаас зохион байгуулсан Ази-номхон далайн бүсийн агро-экологийн асуудлаарх зөвлөлдөх уулзалтанд оролцсон зарим төлөөлөгчидын хамт

### **Хоршоодын эдийн засгийн чадавхийг сайжруулах талаар хийсэн ажил**

2015 оны 12 сарын байдлаар тус холбооны гишүүн хоршоодоос давхардсан тоогоор 12 хоршоо сум хөгжүүлэх сан, мал хамгаалах сан болон ХААН банкнаас 200 гаруй сая төгрөгийн зээл авч 20 гаруй ажлын байрыг шинээр буй болгосон байгаа нь хоршоод зээлд хамрагдах боломж сайжирч байгааг харуулсан нэг үзүүлэлт боловч одоогоор зээлийн материалаа бүрдүүлж банканд өгсөн хэдий боловч эдийн засгийн хямрал үүссэн, зээл хязгаарлах зарим шийдвэрээс хамаарч хоршоодын зээлийг банкууд олгохгүй ихээхэн хүлээлт үүсгэж ажил, орлогыг гацааж буй асуудал байна.

2015 онд зээл болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр Эрдэнэдалай сумын “Далайн хөгжил” хоршоо 160 хүнд нэгэн зэрэг үйлчлэх хүчин чадалтай зоогийн газар бүхий үйлчилгээний тэнхим, караоке кафе, үсчин, зурагчин зэрэг үйлчилгээний иж бүрэн цогцолбор шинээр барьж дуусган бүрэн ашиглалтанд оруулсан.

Энэ тайланд 2015 онд Улсын тэргүүний хоршоогоор шалгарсан Адаацаг сумын Амьдралын туг хоршооны ажлын амжилтаас дурдах нь зүйтэй гэж үзлээ.

“Амьдралын туг” хоршоо 1996 онд байгуулагдсан, мал аж ахуй, хадлан, худалдаа үйлчилгээ эрхэлдэг үйл ажиллагаа нь тогтворжсон аж ахуй юм. 2015 оны эцсийн байдлаар 63 өрх айл, 631 гишүүдтэй Адаацаг сумын нийт малчин өрхийн 60 гаруй хувь хамрагддаг, хоршооны гишүүдийн 45000 гаруй толгой малтай, хоршоо өөрөө 510 толгой малтай, нийт 17 ажиллагсадтай жилд дунджаар 30 орчим сая төгрөгийн борлуулалт хийж 3.25 сая төгрөгийн ашигтай ажиллаж байна.

“Амьдралын туг” хоршоо 10 ширхэг трактортай хадлангийн иж бүрэн салаатай, шатахуун түгээх станцтай, говийн аймагууд дунд хадлан бэлтгэдэг ганц аж ахуй бөгөөд энэ чиглэлээр 18 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж, аймаг, сумдын аюулаас хамгаалах нөөцийн өвсийг бэлдэхээс гадна хоршооныхоо малчдын өвсний хэрэгцээг бүрэн ханган ажиллаж байна.

2014-2015 онд өөрийн дэлгүүр болон 3 өрөө бүхий зочид буудал, зоогийн газарт их засвар хийж үйлчилгээний төрөл хэмжээг нэмэгдүүлсэн, нийт 1200 тн өвс хадаж, боож тээвэрлэн малчид гишүүдэдээ хүргэж үйлчилсэнийг онцлон тэмдэглэж байна. Говийн малчдын хэрэгцээ шаарлагыг хангасан **“Өвс-тэжээл” нь тус хоршооны бренд** бүтээгдэхүүн болсон юм.

“Амьдралын туг” хоршоо ажлынхаа амжилтаар улсын 100 шилдэг аж ахуйн нэгжид шалгарч байсан манай аймгийн тэргүүний бүтээлч хамт олон. Тус хоршоо нь гишүүн малчдынхаа ноос, ноолуур, арьс шир түүхий эдийг нэгтгэн авч борлуулдаг тогтсон

сүлжээтэй, улс, бүс, аймгийн үзэсгэлэн, худалдаанд тогтмол амжилттай оролцдог, санхүүгийн хувьд бэхэжсэн, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн стандартыг хангаж ажилладаг. Эдгээр амжилтууд нь тус хоршооны дарга, АИХ-ын депутат асан Ж.Тувааннайдан, МУ-ын санхүүгийн тэргүүний ажилтан, нягтлан бодогч Б.Балжинням нарын 20 гаруй жил гар, сэтгэл нийлж, хоршоологч гишүүдтэйгээ нягтарч, хамтарч ажиллаж буйн үр дүн юм.

#### **4. Аймгийн холбооны биечлэн гүйцэтгэсэн ажлын талаар**

Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 10-р хурлыг 2015 оны 6-р сарын 19-20-ны өдөр Мандалговь хотод зохион байгуулж хуралдуулсан. Хуралд 15 сумын 27 хоршооноос сонгогдсон төлөөлөгчид оролцож, аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо болон хоршоологчдын өнөөгийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны шинэ байшинг ашиглалтанд хүлээн авах асуудлуудыг хэлэлцэж зохих шийдвэр гаргасан.



Бага хуралд Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний Холбооны ерөнхийлөгч Д.Сумьяабазар, дэд ерөнхийлөгч Алтантуяа, мэргэжилтэн Индра нар урилгаар оролцсон. МХААХҮХ-ны ерөнхийлөгч Д.Сумьяабазар тэргүүтэй төлөөлөгчид аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны шинэ байрны нээлтэн ажиллагаанд оролцож, дурсгалын зүйл гардуулсан. Бага хуралд Дундговь аймгийн ХААЖДҮГ-ын орлогч дарга Л.Хүүхэнхүү, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн хоршоо хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяр нар урилгаар оролцсон.

Бид Үндэсний холбооныхоо дэмжлэгтэйгээр аймгийн Холбооны байрыг шинээр барьж, нийт 120 квадрат метр ашигтай талбай бүхий офиссын 2 өрөө, хурлын заал, ариун цэвэрийн 2 өрөөтэй, мансардын 30 квадрат метр талбай бүхий өрөөнд зочид буудал байгуулж



тохижуулан 2015 оны 6-р сарын 19-ны өдөр нээлтээ хийж ашиглалтанд оруулсан, мөн бид өөрсдийн хүч хөрөнгөөр гадна хашааг сэлбэж явган хүний болон машин орох гүйдэг хаалга хийж орчиныг тохижуулсан.



Аймгийн Хоршоологчын Холбооны дэргэд “Хоршоодын мэдээллийн сан” буй болгон гишүүн хоршоод болон нийт гишүүдийг шуурхай мэдээлэлээр хангах арга хэмжээг авч ажиллаж байна.



Хулд сумын “Олдохын дэвжих” хоршоо мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл хослон эрхлэж байгаагаас гадна говийн нөхцөлд 10 га газарт ойн төгөл буй болгосон ажлын амжилтаараа 2015 онд бусад хоршоодоо манлайлаж байна.

Сум бүрт “Дундговь аймагт хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хүргүүлсэн бөгөөд хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөрт хоршоодыг хамруулах талаар сумдын засаг дарга нартай тулж ажиллаж байна.

Аймгийн тэргүүний хоршоог шалгаруулан урамшуулах болзол гаргасан, хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулна.



“Мандалговь хүнс” ХХК манай хоршоологчдын Алтан түншлэгч байгууллагаар шалгарч Алтан түншлэгч өргөмжлөл гардсан .

Тухайн хоршооны брэнд бүтэгдэхүүнийг шалгаруулж, уг бүтээгдэхүүнийг сурталчлах, сумынхаа иргэдийн хэрэгцээг хангадаг болгох арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ ажлыг зөвхөн гишүүн хоршоодын явцуу хүрээнд биш аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны түншлэгч шалгаруулах журам гарган хоршоологчид малчидаас санал авахад аймгийн гол хүнс үйлдвэрлэгч “Мандалговь хүнс” ХХК манай хоршоологчдын Алтан түншлэгч байгууллагаар шалгарсан.

#### **6. Цаашидын зорилтын талаар**

1. Аймгийн Хоршоологчдын Холбооны дэргэдэх “Хоршоодын мэдээллийн сан”-г тогтмол шинэчилж гишүүн хоршоод болон нийт гишүүдийг шуурхай мэдээлэлээр хангах арга хэмжээг тогтмолжуулна.

2. Сум бүрийг хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөрт хамруулах, сумын тэргүүний хоршоог шалгаруулан урамшуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтарч уламжлал болгон зохион байгуулна.

3. Тухайн хоршооны брэнд бүтэгдэхүүнийг шалгаруулж, уг бүтээгдэхүүнийг сурталчлах, сумынхаа иргэдийн хэрэгцээг хангадаг болгох арга хэмжээг зохион байгуулна.

4. Сумын засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг дүгнэхдээ хоршооны хөгжилд оруулсан хувь нэмрийг нэг шалгуур болгох асуудлыг үргэлжлүүлэн тавьна.

5. Сум хөгжлүүлэх сангаас хоршоодод зээл олгох асуудалд байнга анхаарал хандуулж, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

## 7. Санал

Үндэсний холбооны ерөнхийлөгч, удирдлагуудад дараах саналуудыг ажил хэрэг болгохыг уламжлаж байна. Үүнд:

1. Хоршооны тухай Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын чуулганаар хэлэлцэх үед хуулиудын зөрүүтэй заалтуудыг нэг мөр болгох.

2. Иргэний хуульд хоршооны тухай хуулийг нийцүүлж, хоршоог дэмжсэн эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, хоршооны гишүүдээс хүлээн авсан ноос, ноолуурыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх

3. Төр, хоршоодын хамтын ажиллагааны түншлэлийн зөвлөлийг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, багийн түвшинд байгуулж ажиллах улмаар хоршооллын байгууллагад ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх

4. МУ-ын Засгийн газрын бодлого, шийдвэрээр тухайн үед Хөдөлмөрийн яамнаас хоршоодын чадавхийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ буй болгох, чадвар бүхий, тусгай шалгуур хангасан загвар хоршоонд олгох ёстой байсан 50.0 сая төгрөгийг манай аймгийн удирдлагууд өөрсдийн оролцоотой дан төрийн албан хаагч 9 гишүүнтэй шинэ байгуулагдсан “Хөх зуут” гэх хоршоонд олгосон нь манай гишүүн олон хоршоодын урамыг хугалсан улмаар хууль зөрчсөн ноцтой үйлдэл болсон талаар хурал болгон дээр ярьж шүүмжлэл тасрахгүй байна. Иймд энэ асуудлыг Үндэсний холбооноос Аж Үйлдвэрийн яаманд албан ёсоор тавьж шалгуулахыг санал болгож байна.

5. Хөгжлийн банкнаас хоршоодод олгох зээл, үзүүлэх санхүүгийн үйлчилгээг тодорхой болгох зэрэг саналыг тавьж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН

ХОЛБООНЫ ДАРГА

Д.ЧАНДМАНЬ